

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ТОГТООЛ

2008 оны 11 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 251

Улаанбаатар хот

“Футур эволюцион ББСБ” ХХК-ийн банк бус
санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зарим тусгай зөвшөөрлийг
сэргээж, зарим тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1.1, 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.4, 13.3, Хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 10.4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Футур эволюцион ББСБ” ХХК-ийн Банк бус санхүүгийн зээл, гадаад валютын арилжаа, төлбөрийн баталгаа гаргах, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээсүгэй.

2. “Футур эволюцион ББСБ” ХХК-ийн санхүүгийн түрээс, факторингийн үйлчилгээ, итгэлцлийн үйлчилгээ, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах зэрэг үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

3. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Футур эволюцион ББСБ” ХХК /Роберто Ди Серио/-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ